

Цогтбаярын Цэлхагарав^{1✉}

¹Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн Археологийн хүрээлэн,
Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө,
Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

“Монгол нутаг дахь хиргисүүрийн судалгаа, түүний гадаад бүтэц зохион байгуулалтын ангиллын асуудалд” эрдэм шинжилгээний өгүүлэлд өгөх шүүмж

Товчлол. Судлаач Т.Идэрхангай, Х.Уянга нар МУИС-ийн Улаанбаатар их сургуулиас цувралаар эрхлэн гаргадаг “Journal of the Archaeology, History and Humanitarian” сэтгүүлийн 2022 оны 18-р дугаарын 39-60 дугаар талд “Монгол нутаг дахь хиргисүүрийн судалгаа, түүний гадаад бүтэц зохион байгуулалтын ангиллын асуудалд” нэртэй нэгэн эрдэм шинжилгээний өгүүлийг нийтлүүлжээ. Гэвч энэхүү өгүүлэлд хэрэглэсэн мэдээллийн сангийн нарийвчлал нь нэлээд эргэлзээтэй, дурсгалын ангилал зүйн зарчим нь хэт зөрчилтэй, сүүлийн үеийн судалгааны үр дүнг сайн харгалзаж үзээгүй, санал дүгнэлтүүд нь тодорхой үндэслэл, баримт нотолгоо муутай, зарим талаар хэтэрхий хийсвэр хэмээн үзэж байгаа тул 6 хэсэгт шүүмжийг өгч өөрийн саналыг дурдсан болно.

Түлхүүр үг: Хиргисүүр, гадаад бүтэц зохион байгуулалт, ангилал, утга бэлгэдэл

Tselkhagarav Tsogtbayar^{1✉}

¹Institute of Archaeology,
Mongolian Academy of Sciences Building-1,
Peace avenue, Ulaanbaatar-13330, Mongolia

**A review for the article titled
“The study of Mongolian khirgisuur and its external structural typology issues”**

Summary. Researchers T.Iderkhangai and Kh.Uyanga published an article entitled “Study of khirgisuur in Mongolia and classification of its external structure in Journal of the Archaeology, History and Humanitarian for the issue 18, 2022. Nevertheless, the accuracy of the database used in this article is quite questionable, the classification principle of monuments is too contradictory, recent research results have not been well considered, thier view and conclusion lack clear grounds and evidence, and some are overly abstract, so it cannot be acceptable as an academic classification. In this article, the review is presented in 6 parts and includes some suggestion.

Key words: Khirgisuur, external structure organization, classification, symbolic meaning

Удиртгал

Төв Азийн эртний нүүдэлчдийн нэгэн ээдрээтэй бөгөөд сонирхолтой үе шатыг төлөөлөх томоохон дурсгал бол хиргисүүр юм. Хүрлийн үеийн сүрлэг дурсгал болох Буган хөшөөний хамт “Хиргисүүр-Буган хөшөө”-ний хүчирхэг соёлыг бүрдүүлж байсан бөгөөд тархалтын цөм, соёлын голомт нь өнөөгийн Монгол нутаг мөн болох нь эргэлзээгүй билээ. Иймд энэхүү дурсгалын судалгааны хөгжилд манай улсын судлаачдын үүрэг хариуцлага, хүчин чармайлт чухал үүрэг гүйцэтгэх учиртай. Түүнчлэн урьд өмнө төдийлөн хангалттай бус байсан лабораторийн судалгаа, мэдээллийн сангийн хөгжил бидэнд цоо шинэ боломжийг нээж хиргисүүрийн судалгааны зарим асуудлыг шинээр харах, хөндөн хэлэлцэх чухал үе тохиож байгаа билээ.

Судлаач Т.Идэрхангай, Х.Уянга нар МУИС-ийн Улаанбаатар их сургуулиас цувралаар эрхлэн гаргадаг “*Journal of the Archaeology, History and Humanitarian*” сэтгүүлийн 2022 оны 18-р дугаарын 39-60 дугаар талд “Монгол нутаг дахь хиргисүүрийн судалгаа, түүний гадаад бүтэц зохион байгуулалтын ангиллын асуудалд” нэртэй нэгэн эрдэм шинжилгээний өгүүллийг нийтлүүлжээ. Энэхүү өгүүлэл нь товчлол, удиртгал, хиргисүүрийн гадаад бүтцийн ангилал, хүрээтэй хиргисүүр, дөрвөлжин хүрээтэй хиргисүүр, хиргисүүрийн утга зүйн товч тайлбар, дүгнэлт, хураангуй, хавсралт, ном зүй зэрэг бүлэг зүйлүүдээс бүрдэх бөгөөд нийт 22 нүүр бүхий том хэмжээний өгүүлэл болжээ.

Өгүүллийн удиртгал хэсэгт зохиогчид өөрсдийн судалгааны эх хэрэглэгдэхүүний тухай дэлгэрэнгүй өгүүлж, хиргисүүрийн судалгааны зарим үндсэн асуудлыг хөнджээ. Үүнээс хиргисүүрийн бүртгэл, мэдээллийн санг бий болгох нь нэлээд төвөгтэй, хөдөлмөр шаардсан ажил болохыг тодорхой харж болох бөгөөд үүнд залуу судлаач Х.Уянгын уйгагүй хичээл зүтгэл гол үүрэг гүйцэтгэжээ (тал 39-42).

Мөн хиргисүүрийн гадаад бүтцийн ялгаатай байдал нь улс төр, нийгмийн зохион байгуулалт, зан үйлийн олон чухал асуудлыг тодруулах боломжтой хэмээн үзэж судалгааны гол зорилгоо тодорхойлсон байна. Зохиогчид өмнөх судлаачдын хийсэн хиргисүүрийн ангиллыг авч үзэхийн зэрэгцээ нэмж баяжуулах шаардлагатай хэмээн үзжээ. Түүнчлэн бүртгэл, мэдээллийн сан бий болгох явцад хайгуул судалгааны арга зүй болон “булш хиргисүүр” гэх нэршлийн хэт ерөнхий байдал судалгааны ажилд хүндрэл учруулж байсан тухай дурдсан нь бидний зайлшгүй анхаарал хандуулах, хөндөн хэлэлцэх чухал асуудлын нэг мөн билээ. Зохиогчид цуглуулсан эх хэрэглэгдэхүүнд үндэслэн өгүүллийн үндсэн санаа

болох өөрсдийн ангиллын хувилбарыг дэвшүүлсэн бөгөөд хиргисүүрийг үндсэн 3 бүлэг болгон дотор нь дэд бүлгүүдэд ангилан дэлгэрэнгүй өгүүлж, статистик үр дүн, тоо баримтыг танилцуулжээ (тал 42-53).

Хиргисүүрийн бүрдэл хэсгүүдийг утга бэлгэдлийн талаас тайлбарлах оролдлого нь нэлээд өвөрмөц хандлагатай, шинэ маягийн тайлбар болжээ. Мөн хиргисүүрийн гадаад бүтцийн бүс нутгийн ялгаа, тархац, зүй тогтол, байршил зүйн онцлогийн талаар өөрсдийн санал, таамаглалыг дэвшүүлж, зарим сонирхолтой ажиглалт хийсэн нь ач холбогдолтой юм (тал 53-56). Хэдийгээр дээрх ололттой талууд бий боловч зарим нэг зүйлсийг эргэн харах, нягтлах шаардлага байна хэмээн үзэж дараа дараагийн судалгаанд нэмэр болох болов уу хэмээн доорх хэдэн зүйлсийг энд дурдахыг хүсэв.

Юуны өмнө энэхүү өгүүлэлд хэрэглэсэн мэдээллийн сангийн нарийвчлал нь нэлээд эргэлзээтэй, дурсгалын ангилал зүйн зарчим нь хэт зөрчилтэй, сүүлийн үеийн судалгааны үр дүнг сайн харгалзаж үзээгүй, санал дүгнэлтүүд нь тодорхой үндэслэл, баримт нотолгоо муутай, зарим талаар хэтэрхий хийсвэр байгаа тул эрдэм шинжилгээний ангилал хэмээн үзэхэд учир дутагдалтай байна. Иймд тус өгүүлэлд дараах 6 хэсэгт шүүмжийг өгч байна.

1. Зохиогчид олон зуун хэрэглэгдэхүүнийг шүүж их хэмжээний хөдөлмөр зарцуулсан нь ном зүйд байгаа хэдэн зуун тайлан, мэдээ баримтаас тодорхой мэдэгдэнэ. Дээрх байдлаар манай улсад археологийн үндэсний мэдээллийн сангууд төлөвшин бий болж, судалгаанд нэвтэрч байгаа нь сайшаалтай байна. Тэд нийт 20140 хиргисүүрийн мэдээллийн санг бүрдүүлсэн тухай дурдсан бөгөөд үүний 50 гаруй хувь буюу 10956 дурсгалын гадаад бүтцийн тухай мэдээлэл тодорхойгүй, 9184 дурсгалын мэдээлэлд тулгуурлажээ (тал 39, 46).

Хиргисүүрийн тархалтын хил хязгаарыг тогтоохдоо зохиогчид судалгааны эх сурвалжийг сайн нягталсангүй. Тодруулбал, хиргисүүрийн хамгийн зүүн зах нь Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутаг Наран уул, өмнөд зах нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Жавхлант бригад хэмээн үзэж эрдэм шинжилгээний тайлангаас эш татсан байна (тал 45). Гэтэл Сүхбаатар аймгийн Наран уул хэмээх газарт хиргисүүр бүртгэгдсэн тухай мэдээлэл олдсонгүй. Өмнөговь аймгийн Жавхлант бригадын дурсгал нэгэнт эвдэгдэж тоногдсон байх бөгөөд хиргисүүрийн хэв шинжийг илэрхийлэх боломжгүй гэдэг нь тодорхой байна. Өмнөх жилүүдэд судалгааны баримт хэрэглэгдэхүүн хангалттай хэмжээнд бүрдээгүй байсантай холбоотой “хиргисүүр” хэмээх нэр томьёо нь ихэвчлэн “Булш-хиргисүүр” гэх холбоо үг маягаар хэрэглэгдэж олон төрлийн

дурсгалуудыг хэт ерөнхийлөн авч үздэг нийтлэг хандлага олон жил үргэлжилж ирсэн бөгөөд тухайн үеийн эх хэрэглэгдэхүүнд шүүлтүүртэй хандаж, хиргисүүрийг бусад дурсгалаас ялган авч үзэх бодит шаардлага бий болоод байгаа билээ.

Мөн зохиогчид Монгол улсын хэмжээнд 248 хиргисүүрийг малтан судалсан тухай тоон мэдээллийг дурдсан нь (тал 54) мөн л нягтлан үзүүштэй тоон үзүүлэлт болно. Дурдсанчлан, олон хэв шинжийн дурсгалыг хиргисүүрт хамааруулах нийтлэг үзэгдэл түүний малтлага судалгааны тоо баримтад мөн нөлөөлсөн байж болохыг анхааран үзэх нь зүйтэй болов уу.

2. Өгүүлэлд санал болгосон ангилал нь өмнөх судлаачдын хиргисүүрийг ангилсан ерөнхий зарчимтай төстэй боловч хамгийн олон төрлийн хувилбарыг дэвшүүлснээрээ эрс ялгарна. Тодруулбал, хиргисүүр нь хүрээтэй болон хүрээгүй, сонгодог цогцолбор байгууламжтай хэмээх 3 үндсэн бүлэг бөгөөд нийт 126 төрлийн ялгаатай хэв шинж байна хэмээн үзжээ (тал 39-57). Ангиллыг ихэвчлэн хиргисүүрийн бүрдэл хэсгүүд, тэдгээрийн байрлал болон тоон үзүүлэлтэд тулгуурласан бөгөөд хиргисүүрийн тахилгын зан үйлийн чухал элемент болох дагуул байгууламжийг төдийлөн харгалзаж үзээгүй бололтой.

Жишээлбэл, зөвхөн “цаураг” хэмээх хиргисүүрийн нэгэн элементийн тоон үзүүлэлтээр нь нийт 10 гаруй төрөлд ялган ангилжээ. Ийм байдлаар хиргисүүрийн бусад бүрдэл хэсгүүд болох “зам”, “дагуул байгууламж” болон бусад байгууламжийн тоон мэдээлэл, байршилд тулгуурлан олон арван төрөл үүсгэн тус бүр бие даасан ангиллын нэгж бий болгосон байна.

Хиргисүүр нь олон хэсгээс бүрдэх нарийн нийлмэл бүтэц зохион байгуулалттай бөгөөд өргөн уудам бүс нутагт түгэн тархсан олон мянган тоотой уг дурсгал нь он цаг, нийгэм, эдийн засаг, аж ахуй, бүс нутгийн онцлог гэх мэт олон хүчин зүйлээс шалтгаалан бүрдэл хэсгүүд болон дагуул байгууламжийн тоо, хэлбэр хэмжээ, тэдгээрийн байрлал зүй харилцан адилгүй байх нь ойлгомжтой. Иймд дээрх ялгаатай шинжид үндэслэн ангилал үүсгэх нь агуулгын хувьд боломжгүй, эцсийн үр дүн нь ойлгомжгүй болох юм. Мөн археологийн дурсгалууд нь үйлдвэрт нэгэн хэвэнд цутгасан мэт яг адил байдаггүй бөгөөд бага зэргийн хазайлт үргэлж гарч байдгийг ч харгалзан үзүүштэй.

3. Аливаа ангилал зүйн нэгж бодитой оршиж байна гэж үзвэл нэлээд итгэмжтэй тоон үзүүлэлтэй байх учиртай. Гэтэл зарим төрөл нь ангилал үүсгэх хэмжээний төлөөлөлтэй эсэх нь ихэд эргэлзээтэй байна. Үүнд давхар хүрээ, хагас дугуй хүрээ зэрэг төрлүүдийг дурдаж болно (тал 46-47). Тухайлбал, хагас дугуй хүрээтэй гэх хиргисүүр нь ердөө 10 буюу нийт 20140 дурсгалын 0,05 хувь, гадаад

бүтцийг тодорхойлсон 9184 дурсгалын 0,1 хувь, давхар хүрээтэй (2 болон 3) хиргисүүр нь нийтдээ 17 буюу нийт дурсгалын 0,08 хувь, 9184 дурсгалын 0,2 хувь болно. Иймд нийт дурсгалын нэг хувьд ч хүрэхгүй хэтэрхий бага байгаа тул ангиллын нэгэн бие даасан бодит төрөл гэж үзэх хэр зохистой вэ гэсэн асуулт төрж байна. Харин онцгой тохиолдол хэмээн дурдах боломжтой мэт.

4. Зарим төрлийн үндэслэл болгож буй чулуун байгууламж нь тухайн дурсгалтай он цагийн хувьд шууд хамааралтай эсэхийг цаашид нягтлан үзэх шаардлагатай байна. Хиргисүүрийн байршил, материал зэрэг нь дараа дараагийн үеийнхний бэлэн боломж байсаар ирсэн билээ. Жишээлбэл, үүнд хэд хэдэн шинэ төрөл үүсгэх үндэслэл болгосон “эвэр хэлбэр”-ийн гэх байгууламжийг дурдаж болно. Тухайлбал, хүрээгүй хиргисүүрийг нийт 9 ангилсан байх бөгөөд “овгор чулуун дарааснаас 1 тийш дугуйрсан эвэр хэлбэрийн чулуун байгууламжтай”, “овгор чулуун дарааснаас 2 тийш дугуйрсан эвэр хэлбэрийн чулуун байгууламжтай” хэмээн 2 төрөлд ангилсан бол мөн дугуй болон дөрвөлжин хүрээтэй хиргисүүрт “... зүүн болон баруун тийш хагас дугуйрсан эвэр хэлбэрийн байгууламжтай” (тал 46-47) байдаг гэж үзэж хүрээний хэлбэр тус бүрт дахин 2 төрөл нэмж үүсгэжээ. Гэтэл дээрх байгууламжийг хиргисүүрийн бүтцийг илт эвдэн байгуулсан байх нь түгээмэл тохиолддог [Wright 2007: 359, fig 3-5] тул хожуу үед үйлдсэн байх магадлалтай.

5. Сүүлийн жилүүдэд хэвлэгдсэн хиргисүүртэй холбоотой олон тооны үнэмлэхүй он цагийн үр дүнг харгалзаж үзээгүй нь өөрсдийн хийсэн ангиллыг бодит бус, хэврэг болгосон байж болох юм. Жишээлбэл, өмнө нь хиргисүүрт хамааруулан үзэж байсан “Сагсай хэлбэрийн були” нь хиргисүүрээс илүү эрт үед холбогдох нь сүүлийн жилүүдэд хийгдсэн үнэмлэхүй он цагийн судалгааны үр дүнд тогтоогдоод байгаа бөгөөд түүнийг хиргисүүрийн дэд төрөлд багтаасан нь зарчмын хувьд алдаатай болжээ. Иймд хиргисүүр болон түүнд хамааруулан үзэж буй дурсгалуудын ангиллыг зөвхөн гадаад бүтцэд хэт тулгуурлах нь бодит байдалтай төдийлөн нийцэхгүй байна.

6. Зохиогчид хиргисүүрийн бүрдэл хэсгүүдийг зөвхөн ангилал зүйн төрөл үүсгэх үндэслэл болгоод зогсохгүй утга бэлгэдлийн талаас тайлбарлах зарим оролдлого нь нэлээд зөрчилтэй болжээ. Тухайлбал, голын овоолго нь “гэрийг төлөөлдөг” байж болох тухай дурдаад “дугуй болон дөрвөлжин хүрээ нь тухайн хүний сүнсний орон зай, хил хязгаарыг зааглаж байна”, харин “дөрвөн буланд босгосон хөшөө чулуу нь түүний сүнсний хамгаалагчид байж болох” (тал 53-54) тухай таамаг дэвшүүлжээ. Гэтэл хиргисүүрийн соёлын бүрэлдэхүүнд багтах буган хөшөө нь

хүнчилсэн дүр болох нь улам бүр тодорхой болсон бөгөөд тухайн нас барсан хүнийг тэнгэрт гаргаж байна гэсэн утга бэлгэдлийг агуулж байдаг тухай олон судлаачид үзэж угсаатны зүйн мэдээ баримтад тулгуурлан тайлбарласан байдаг [Баярсайхан 2017: 209; Төрбат 2021: 135-136]. Иймд зохиогчдын дэвшүүлсэн тухайн хүний сүнсийг “хорих” утга агуулга төдийлөн үнэмшилтэй тайлбар болж чадахгүй бөгөөд үүнтэй холбогдуулан олон арваас хэдэн зуун адууны тахилгыг хэрхэн тайлбарлах асуудал ойлгомжгүй байна. Мөн зарим судлаачийн дэвшүүлсэн хиргисүүрийг “тэрэгний загвар” байж болох тухай сонирхолтой таамаглалын талаар энд дурдсангүй нь харамсалтай. Тэрхүү загвараар бол зүүн зүгт хандуулж тавьсан адууны толгой бүхий зүлдүүд нь тэргэнд хөллөсөн адуу, харин хиргисүүрийн хүрээ нь тэрэгний тавцан, дөрвөн буланд нь байгаа чулуун овоолго бол тэрэгний дугуй болдог [Худяков 1987: 158; Батсайхан 2002: 130; Taylor et al. 2021: 14, fig 9; Lepetz et al. 2021: 280-282, 571 pp].

Мөн зохиогчид “зам” хэмээх байгууламж нь оршуулга руу тусгайлан орох зам хэмээн тайлбарласан байна. Гэвч дээр өгүүлсэнчлэн тухайн хүний сүнсийг хоёр төрлийн хүрээгээр “хязгаарлаж” сэргийлдэг юм бол тусгайлан зам байгуулж нэвтрэх шалтгааныг тайлбарлаагүй байна. Мөн энэхүү “зам” хэмээх байгууламж нь зөвхөн “*том хэмжээний удирдагчийн нүсэр байгуулсан хиргисүүрт тааралддаг*” хэмээн үзсэн нь бага зэрэг эртэдсэн дүгнэлт бөгөөд жижгэвтэр хиргисүүрт ч мөн цөөнгүй тохиолддог билээ.

Зохиогчид хиргисүүрийн “*дөрвөн буланд битүү дараастай чулуун байгууламж үйлдсэн нь дөрвөн зүгийн дус савдгийг аргадах тахилгын зориулалттай зан үйл*” гэсэн санал дэвшүүлсэн хэдий ч энэхүү байгууламжийг манай улсад цөөнгүйг малтан судалсан боловч тахил тайлга үйлдсэн зан үйлийн ул мөр одоогоор илрээгүй байгааг анхаарах нь зүйтэй юм.

Түүнчлэн “*Хиргисүүр хэмээх нэгэн хэв шинжийн бөгөөд зөвхөн нэмэлт деталь байгууламжаараа 126 төрлийн ялгаатай үйлдсэн явдал нь хүрэл зэвсгийн үед тархай бутархай байсан олон том овгуудыг нэгтгэн захирсан нэгэн нүсэр аймгийн холбооны улс байсныг харуулж байна*. Угсаа салсан овгууд хоорондоо ялгагдахын тулд нэмэлт байгууламжийг үйлддэг байсан байж болох юм” хэмээгээд ... “*овгийн тамга*”-тай зүйрлэсэн бол хиргисүүрийн гадаад бүтцийн ялгааг мөн нийгмийн давхраажилттай холбон үзэж “*энгийн жижиг хүрээгүй хиргисүүрүүд нь эгэл жирийн ардууд, хүрээтэй нь түүнээс дээш зиндааны дайчин эрст, энгийн дөрвөлжин хүрээтэй нь ноёлох овгийнхонд, дөрвөлжин хүрээтэй дөрвөн*

буландаа байгууламжтай нь ноёлох овгийн язгууртан ноёдууд, түүнээс томроод дагуул деталь байгууламжууд нь хэдэн зууд хүрэх нь овог аймгийн сайд түшмэдүүд, хамгийн том нүсэр хэмжээтэй буюу 1000-аас дээш дээш тахилтай нь энэ соёлынхны хаад, овгийн удирдагчийнх” (тал 56) хэмээн тус тус дүгнэсэн байна. Гэвч эдгээр дүгнэлтүүд нь нэлээд механик маягийн шинжтэй, баримт нотолгоогүй, хэтэрхий хийсвэр болсон бөгөөд зохиогчид дурсгалын гадаад бүтцэд хэт анхаарал хандуулж, угсаа соёлын нарийн чухал үйл явц, хувьсал хөгжил болон он цагийн ялгаа байж болох хувилбарыг анзааралгүй орхигдуулжээ.

Мөн Монголын археологийн судалгаанд урьд өмнө хэрэглэж байгаагүй “аймгийн холбооны улс” болон “холбооны маягийн улс” хэмээх нэр томъёоны утга агуулгыг тодорхой задлан тайлбарлаагүй бөгөөд нүүдэлчдийн нийгэм, төрийн зохион байгуулалтын онцлог, бүрэлдэн бий болох түүхэн үйл явц, түүний шалтгаан нөхцөл, аж ахуй, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийн нөлөөлөл, газар зохион байгуулалтын талаарх олон үзэл санаа, судалгааны бүтээлүүдэд [Ханичёрч, Амартүвшин 2006; Wright 2007; 2014; Frohlich et al. 2009; Houle 2009; 2010; Fitzhugh 2009; Honeychurch 2013; Жаргалан 2022] анхаарал хандуулж энэхүү нэн чухал судалгааны асуудлыг илүү нухацтай авч үзэх нь зүйтэй болов уу.

Түүнчлэн ... “*сонгодог хэлбэрийн буган хөшөө бүхий цогцолборууд овог аймгийн тахилын газар бололтой*. Тэнд “*томоохон дайн тулаанд овог аймгаа төлөөлөн амь эрсэдсэн дайчин баатар эрсийн гавьяаг мөнхлөх үүднээс овог аймгаараа хүндэтгэл үзүүлдэг тахилын газар*” (тал 56) хэмээн үзжээ. Гэвч буган хөшөө, хиргисүүрийн томоохон цогцолборуудыг нийтэд нь “амь эрсэдсэн” дайчдад зориулан бий болгосон гэх дээрх таамаглалын үндэслэл болон антропологийн судалгааны үр дүн тодорхойгүй байна.

Мөн зохиогчид хиргисүүрийн болон бусад дурсгалын гадаад бүтцийн ялгааг зөвхөн нийгмийн давхраажилттай холбон үзэх [Цыбиктаров 2002: 175-176; Амгалантөгс 2021: 36-42] болон хиргисүүрийн гаднах хүрээний бүс нутгийн ялгаа [Амартүвшин, Цэлхагарав 2018: 63-65] зэрэг нь шинэ үр дүн биш бөгөөд энэ талаар өмнө нь судлаачид өөрсдийн саналаа дэвшүүлсээр ирсэн байдаг.

Ийнхүү Монголын археологийн судалгаанд сүүлийн жилүүдэд хамгийн сонирхолтой хэлэлцүүлэг өрнөж буй томоохон сэдэв болох хиргисүүрийн судалгаа, түүний тархалт, гадаад хэлбэрийн ангилал, утга санааны талаар өвөрмөц өөр өнцгөөр бичсэн өгүүлэл хэвлэгдэн гарсан нь хиргисүүрийн судалгааны хөгжилд зохих хувь

нэмрээ оруулах нь дамжиггүй. Бид олон талаас нь өөр өөрийн таамаг саналуудыг шинжлэх ухааны үүднээс харилцан солилцож, шүүн тунгааж байж энэхүү чухал дурсгалын судалгаа илүү урагшилж, өргөжин тэлэх юм. Эцэст нь энэхүү шүүмжээр тус судлаачдын судалгааны үр дүнг бүхэлд нь үгүйсгэж байгаа хэрэг огт бус болохыг мөн онцлон тэмдэглэе.

Ном зүй

Амартүвшин, Цэлхагарав 2018 – Амартүвшин Ч., Цэлхагарав Ц. Монгол нутаг дахь хиргисүүрийн судалгаа. – *Studia Archaeologica*. Tom. XXXVII, Fasc. 5. – УБ, 2018.

Амгалантөгс, 2021 – Амгалантөгс Ц. Хиргисүүр хэлбэрийн булш. – *Studia Archaeologica*. Tom. XXXV, Fasc. 4. – УБ, 2021.

Батсайхан, 2002 – Батсайхан З. Хүннү Археологи, угсаатны зүй, түүх/ – УБ, 2002.

Баярсайхан, 2007 – Баярсайхан Ж. Монголын умард нутгийн буган хөшөөд. – УБ, 2017.

Ханичёрч, Амартүвшин 2006 – Амартүвшин Ч., Ханичёрч У. Эртний нүүдэлчдийн төрийн байгууламжинд хийсэн археологийн судалгаа (Эгийн голын сав нутгийн жишээн дээр). – УБ, 2006.

Худяков, 1987 – Худяков Ю.С. Херексуры и оленные камни. – Археология, этнография и антропология Монголии. – Новосибирск, 1987.

Цыбиктаров, 2002 – Цыбиктаров А.Д. Херексуры и памятники монгун-тайгинского типа (проблема культурного соотношения). – Степи Евразии в древности и средневековье. К 100 летию со дня рождения М.П.Грязнова. – СПб., 2002.

Жаргалан, 2022 – Жаргалан Б. Нүүдэлчид: Археологи, нийгэм, аж ахуй. //“Төв ба Дотоод азийн археологи” нэгэн сэдэвт бүтээлийн цуврал-1. – УБ, 2022.

Fitzhugh, 2009 – Fitzhugh, W. Pre-Scythian ceremonialism, deer stone art, and cultural intensification in northern Mongolia. In *Social complexity in prehistoric Eurasia: monuments, metals, and mobility*, edited by B. Hanks and K. Linduff, pp. 378-411. Cambridge University Press, Cambridge.

Frohlich et al. 2009 – Frohlich, B., Amgalantugs, Ts., Littleton, J., Hunt, D., Hinton, J., and Goler, K. 2009 Bronze age burial mounds (khirigsuurs) in the Hovsgol Aimag, Mongolia: a reconstruction of biological and social histories. In *Current archaeological research in Mongolia*, edited by J.Bemmann, H. Parzinger, E. Pohl, and D. Tseveendorj, pp. 99-115. Rheinische Friedrich-Wilhelms-Universität, Bonn.

Honeychurch, 2013 – Honeychurch W. The Nomad as State Builder: Historical Material Evidence From Mongolia. *Journal of World Prehistory*, 2013.

Houle, 2009 – Houle, J.-L. Socially integrative facilities and the emergence of societal complexity on the Mongolian steppe. In *Monuments, metal, and mobility: trajectories of complexity in the late prehistory of the Eurasian steppe*, edited by B. Hanks and K. Linduff, pp. 358-377. Cambridge University Press, Cambridge.

Houle, 2010 – Houle, J.-L. Emergent complexity on the Mongolian steppe: mobility, territoriality, and the development of early nomadic polities. Ph.D. dissertation, University of Pittsburgh, Pittsburgh.

Lepetz et al. 2021 – Lepetz, S., Bernard, V., Cervel, M., Joly, D., Bayarkhuu, N., Saunier, I., Turbat, Ts., Zazzo, A. (2021) Occupation et espaces sacrés dans l'Altai mongol. – Editions Mergoïl, 2021.

Taylor et al. 2021 – Taylor, W., Cao, J., Fan, W., Ma, X., Hou, Y., Wang, J., . . . Miller, B. [2021]. Understanding early horse transport in eastern Eurasia through analysis of equine dentition. *Antiquity*, 95 (384), 1478-1494. doi:10.15184/aqy.2021.146

Wright, 2007 – Wright J. Organizational principles of khirigsuur monuments in the Lower Egiin Gol Valley, Mongolia. – *Journal of Anthropological Archaeology*. Vol. 26, 2007.

Wright, 2014 – Wright J. 2014 Landscapes of inequality? A critique of monumental hierarchy in the Mongolian Bronze Age. *Asian Perspectives*, 51(2).

Өгүүлэл хүлээн авсан: 2023 оны 09 сарын 26

Өгүүлэл засварласан: 2023 оны 10 сарын 14

Өгүүлэл хэвлэгдсэн: 2023 оны 12 сарын 01



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.